

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Товч танилцуулга
- 1.2 Холбооны зохион байгуулалт, орон тоо, хөрөнгийн байдал

ХОЁР. ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

- 2.1 Жолоочийн даатгалын сан бүрдүүлэх, нөхөн төлбөрийн талаар
- 2.2 Мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, холбооны гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох талаар
- 2.3 Даатгалын тохиолдлыг үнэн зөв тодорхойлж үйлчилгээ үзүүлэх Шуурхай албаны талаар
- 2.4 Албан журмын даатгалыг хэрэгжүүлэх, даатгалын тухай хуулийн мэдээлэл, мэдлэгийг олон нийтэд олгох, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны талаар

ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.1 Санхүүгийн тайлан үр дүнгийн талаар
- 3.2 Орон нутгийн салбарын үйл ажиллагаа, үр дүн
- 3.3 Дотоод хяналт, салбар, нэгжийн ажил дүгнэсэн тухай

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

1.1 Товч танилцуулга

Албан журмын даатгагчдын холбоо нь Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрч, Удирдах зөвлөл баталсан дүрэм, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулиар тусгайлан заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагаа явуулж байгаагаараа бусад төрийн бус байгууллагаас ялгагдах онцлогтой.

2019 онд, тус Холбоо нь 36 ажилтны орон тоотой, орон нутагт 20 салбартай, өөрийн өмчлөлийн ажлын байртай, Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиуд, бусад холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа.

2019 онд 17 зорилт дэвшүүлж 56 ажил төлөвлөснөөс 54 ажлын гүйцэтгэлийг бүрэн хангаж 2 ажлын гүйцэтгэл судалгааны түвшинд хийгдэж дараа оны төлөвлөгөөнд шилжлээ.

Удирдах зөвлөлийн 6 удаагийн хуралдаанаар Холбооны 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүнг хэлэлцэж дүгнэн, хууль, дүрэмд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шуурхай албыг ажиллуулах түр журам баталж мөрдүүлэх, даатгалын тохиолдлын дуудлага төвлөрүүлэн хүлээн авах, даатгалын гэрээг цахимаар хийхтэй холбогдуулан МИИС++ системийг хүлээн авч ашиглалтад оруулах, Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 11 тогтоолыг батлуулан үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж байна.

Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, даатгалын компаниуд, зуучлагч, МДХолбооны ажлын хэсэг, бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон 10 гаруй удаагийн танилцуулга, хэлэлцүүлэгт мэдээллийн сангийн МИИС++ систем, бэлэн бус тооцооны тухай, шуурхай дуудлагын нэгдсэн төв ажиллуулах талаар танилцуулж харилцан мэдээ, мэдээлэл солилцож саналыг тусган ажиллалаа.

Удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 02 дугаар хуралдааныг өргөтгөсөн байдлаар хийж нийт даатгалын компаниудын захирал тэднийг төлөөлөх ажилтнуудад Холбооны 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэвлэмэл байдлаар түгээж танилцууллаа.

2019 онд бичиг хэргийн эргэлт нийт 860 байснаас, албан байгууллага, иргэдээс 434 албан бичиг, 45 өргөдөл, гомдлыг тус тус хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн албан байгууллага, иргэдэд нийт 381 албан бичиг явуулсан байна.

Тайлант хугацаанд, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, тав тухтай, эрүүл ажиллах нөхцлийг хангах зорилгоор амралтын өрөөг бялдаржуулах, алжаал тайлах зориулалтын тоноглолоор тохижууллаа. Гүйцэтгэх захирлын 2019 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 02/03 тоот тушаалаар Холбооны эд хөрөнгийн тооллого явуулан эд хариуцагч тус бүрээр нүд үзэн тоолж эд хөрөнгийн картыг шинэчлэн бүртгэлжүүллээ. Цаашид ашиглах боломжгүй 2.5 сая төгрөгийн эд хөрөнгийг актлуулахаар Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлэлээ. Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор орон нутаг дахь салбарын зохион байгуулалтыг өөрчилсөнтэй холбогдуулан 20 салбарын талаарх мэдээллийг, 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Удирдах зөвлөлийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан АЖДХолбооны дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт тус тус бүртгүүлж баталгаажууллаа. 2019 оны бичиг баримтуудыг албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн 56 боть баримт /Увс аймаг дахь салбарын 6, санхүүгийн

23, шуурхай албаны 7, бичиг хэргийн 12, мэдээллийн сангийн 7, дотоод хяналтын 1 боть/-ыг архивт шилжүүллээ.

ХОЁР. ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР:

2.1 ХОЛБООНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫГ ЭХ ҮҮСВЭРЭЭР ХАНГАХ, ХОХИРОГЧИД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛЖ БУЙ ДААТГАЛЫН САНГИЙН ТАЛААР:

Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12^{1.6} дахь хэсэгт зааснаар Холбооны хөрөнгө үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө, элсэлтийн хураамж, гишүүний татвар болон бусад төлбөр, зээл, тусламж, хандив, хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэрээс бүрддэг.

Холбооны орлогыг 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу даатгалын 15 гишүүн компаниудаас бүрэн төвлөрүүлсэн. АЖДХолбооны Удирдах зөвлөлийн баталсан зориулалтын дагуу Холбооны хөрөнгийг зарцууллаа.

Жолоочийн даатгалын сан нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан эх үүсвэрүүдээс бүрддэг. Холбоо нь хуульд заасны дагуу жолоочийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж зарцуулалт, тайлагналтыг хариуцах үүрэгтэй. 2019 онд батлагдсан орон тооны хүрээнд хуулиар даалгасан үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Жолоочийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг хангаж аймаг, нийслэлээс жолоочийн даатгалын санд төвлөрүүлдэг авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувийг төвлөрүүлэх хуваарийг засаг, захиргааны нэгж тус бүрээр сар, улирлаар гарган биелэлтийг тогтсон хугацаанд ханган ажиллалаа.

Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Жолоочийн даатгалын тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлт нь Сангийн сайд, Зам тээврийн сайдын 2013 оны 20/19 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Жолоочийн даатгалын санд хөрөнгө шилжүүлэх журамтай зөрчилдсөний улмаас уг журмыг одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйд нийцүүлэн батлуулахаар холбогдох уулзалтуудыг зохион байгуулж Сангийн яам болон Зам тээвэр Хөгжлийн яаманд асуудлыг тавьж шийдвэрлүүлэхээр ажилласны үр дүнд 2019 оны 06 сарын 25-ны өдрийн 148/222 дугаартай дээрх яамдын сайд нарын хамтарсан тушаал батлагдлаа.

Тайлант хугацаанд жолоочийн даатгалын сан нь нөхөн төлбөр хүссэн 16 өргөдөл хүлээн авч Жолоочийн даатгалын тухай хуулийн 18.1.1 дэх заалтаар 4 этгээд 18 064,0 мянган төгрөг, 18.1.2 дахь заалтаар 1 этгээд 5 252,0 мянган төгрөг, 18.1.5 дахь заалтыг үндэслэн 11 этгээд 39 644,0 мянган төгрөг нийт 16 этгээд 62 690,0 мянган төгрөг нэхэмжилсэн байна. Холбогдох материалуудыг судлан үзэж Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгоход шаардагдах баримт бичгийн бүрдлийг хангаж гэрээ байгуулсан 1 этгээдэд 4,0 сая төгрөгийн нөхөн төлбөр олгож тээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн хариуцлагын даатгалтай 3, даатгалын тохиолдол бус 2, бусад нь хуульд заасан үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр даатгалын сангаас нөхөн төлбөр олгохоос татгалзсан байна. 2 өргөдөл материал бүрдүүлэлтийн шатанд байна. Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийг үндэслэн Даатгалын сангаас нөхөн төлбөр олгодог бөгөөд мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу буцаан нэхэмжилдэг. Хохирогчийн хүсэлтээр даатгалын сангаас нөхөн төлбөрийг олгож буруутай этгээдээс эргэн төлүүлэхэд

хүндрэлтэй, ихэнх буруутай этгээд нь эргэн төлөх чадваргүй, ажилгүй, тогтмол орлогогүй этгээд байх, аль болох эргэн төлөхөөс зайлсхийх, оргон зугатаах хандлагатай байна.

Жолоочийн даатгалын сангаас гаргуулсан нөхөн төлбөрийн буцаан төлөлтийг эрчимжүүлэхээр Холбооны гүйцэтгэх захирлын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан “Даатгалын сангаас нөхөн төлбөр авсан иргэдээс буцаан нэхэмжилж санг хохиролгүй болгох” аяныг зохион байгуулж 9,706,7 мянган төгрөг жолоочийн даатгалын санд төвлөрүүлээд байна. Нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн үлдэгдэлтэй 80 үүрэг гүйцэтгэгчийн мэдээлэл, төлбөрийн үлдэгдлийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулж 24 этгээдийн 33,262,496 төгрөгийн нөхөн төлбөрийн эргэн төлөлтийн үлдэгдэлтэй материалыг шүүхэд шилжүүлэх бэлтгэл хангасан байна. Эрэн сурвалжлах шүүхийн шийдвэртэй 13 этгээдийн /29,467,020 төгрөгийн үлдэгдэл/ оршин суугаа газрыг тогтоох ажиллагаа явуулахаар Цагдаагийн хэлтсүүдтэй хамтран ажиллаж байна. Нөхөн төлбөрөө эргэн төлөхгүй байгаа буруутай этгээдүүд нь ажилгүй, тогтмол орлогогүй, тодорхой хаягт амьдардаггүй, байнга шилжих шилжилтийг бүртгүүлдэггүй иргэд байхаас гадна зарим нь гадаад руу оргон зайлсан байна. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулж тайланг гурав дахь (3.1) бүлэгт тодорхой тусгасан болно.

2.2 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ТАЛААР:

Мэдээллийн нэгдсэн сан нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.1-д заасан чиг үүрэг болон Албан журмын даатгагчдын холбооны гишүүн, даатгагч, даатгуулагч нарт өөрт нь холбогдох мэдээ, мэдээллээр, жолоочийн даатгалтай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй төрийн байгууллага, албан тушаалтанд үнэ төлбөргүй мэдээллээр хангах үүрэг гүйцэтгэдэг. Холбооны гишүүдийн ажлын уялдаа холбоог хангахад мэдээллийн сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн МИИС системийг үнэ төлбөргүй ашиглуулж байгаа төдийгүй жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ байгуулах, хураамж тооцоолох гол үүргийг гүйцэтгэж байна. Даатгуулагчийн төлөх хураамжийн хэмжээг улсын хэмжээнд нэг цэгээс адилхан утга, нэг аргачлалаар тооцоолох системийг ашигласнаар Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журам бүрэн хэрэгжих ач холбогдолтой юм. Жолоочийн даатгалын гол үйл ажиллагааг даатгагчдын зүгээс зөрчилгүй, хэвийн явуулахад Албан журмын даатгагчдын холбооны мэдээллийн нэгдсэн сан голлох нөлөө үзүүлсээр ирсэн, цаашид ч чухал үүрэг гүйцэтгэнэ.

АЖДХ-ны мэдээллийн сангийн МИИС системийн холбогдох хэсгийг сүүлийн үеийн мэдээллийн технологиор сайжруулж бүтээгдэхүүн нийлүүлэх, суурилуулах, өгөгдлийн санг хамгаалах Oracle Advanced Security бүтээгдэхүүн нийлүүлэх суурилуулах тендер зарлаж уг ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулан холбогдох тохиргоо суурилуулалт хийж Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолд заасны дагуу хүлээн авч ашиглалтад орууллаа. Ингэснээр мэдээллийн сангийн өгөгдлийн баазын найдвартай хадгалалт хамгаалалтын түвшин нэмэгдэж мэдээллийн аюулгүй байдал сайжирч байна.

“Мэдээллийн санд даатгалын зуучлагч бүртгэх, түүний хяналтын журам”-ын нэрийг хуульд нийцүүлэн “Мэдээллийн сангийн мэдээллийг ашиглуулах журам” болгон зарим заалтад өөрчлөлт оруулж батлуулав.

Удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоолыг хэрэгжүүлж даатгалын гэрээний хураамжийг бэлэн бус төлбөр тооцоогоор хийх талаар

Миг, Монгол даатгал, Төрийн банк, Хаан банк, Хас банк, Кю пэй, Гэрэгэ пэй ХХК-иудтай хамтран ажиллалаа.

МИИС системийг боловсронгуй болгож, хөгжүүлэх ажлын хүрээнд МИИС++ системийн мобайл апп-ыг хөгжүүлэн тус апп-д даатгуулагч өөрийн гэрээний мэдээллийг шалгах, хугацаагаа харах боломжийг олголоо. Даатгуулагч даатгалын дуудлага өгөх мобайл апп-ыг боловсруулахын тулд Тээврийн цагдаагийн алба, Цагдаагийн ерөнхий газрын холбогдох ажилтнуудтай нийт 3 удаа уулзалт зохион байгуулж тодорхой асуудлаар санал солилцон тохиролцоонд хүрч Санамж бичиг байгуулан ажиллаж байна. Үүний дүнд албан журмын даатгалын дуудлага хүлээн авах мобайл аппликейшнийг Google play store –д байршуулан жолоочийн хариуцлагын даатгалын үйлчилгээг даатгуулагч бүр гар утсаараа дамжуулан авах боломжийг нээж өглөө.

Даатгалын үйлчилгээг бусад оронд хэрэгжүүлсэн дэвшилтэт технологи, туршлагыг нэвтрүүлж даатгалын мэдээллийг блокчэйн сүлжээнд оруулахаар 3 блокчэйн сүлжээг туршиж судалснаар Этириум сүлжээг сонгож даатгалын 5 төрлийн 28 өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж оруулсан техникийн шийдлийг ашиглаж байна.

Албан журмын даатгагчдын холбоо нь Даатгалын тухай хуулийн 12.3.1-д заасан “Албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох” чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 392, 2015 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”, Холбооноос баталсан бусад журам заавруудыг баримтлан даатгалын компани, даатгалын зуучлагчдад тухай бүрт нь чиглэл өгч ажиллаж байна. 2018 онд даатгалын компани, даатгалын зуучлагчдын байгуулсан 655,528 жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний мэдээлэлд түүврийн аргаар нийт гэрээний 38,2%-ийг хянаж үзэхэд даатгалын компаний нийлүүлсэн мэдээллийн 48%, даатгалын зуучлагчид нийлүүлсэн гэрээний 44% нь бүрэн бус мэдээлэлтэй байна. Албан журмын даатгагчдын холбооны Гүйцэтгэх захирлын 2019 оны 08 сарын 28-ны 03/214 тоот албан бичгээр даатгалын компани, даатгалын зуучлагчдад мэдээллийн санд үнэн зөв мэдээлэл ирүүлэх, ажилдаа хариуцлагатай хандах, холбогдох гэрээ, журмыг хэрэгжүүлж ажиллах, алдаагаа засах талаар мэдэгдсэн ч 2019 онд даатгалын компани, даатгалын зуучлагчдын байгуулсан 651,677 гэрээний 99,2%-ийг хянаж үзэхэд 38,5% буюу 248,969 гэрээг байгуулах явцдаа зөрчилтэй мэдээлэл нийлүүлсээр байна. Мөн, даатгагч нар даатгалын нөхөн төлбөрийн мэдээллийг нөхөн төлбөр олгосноос 3 хоногийн дотор мэдээллийн санд ирүүлэх журамтай ч 2019 онд, Миг даатгал ХХК 2,957 нөхөн төлбөр авагчдын 1,5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн мэдээлэл, Монгол даатгал ХХК 1,597 нөхөн төлбөр авагчдын 894,9 сая төгрөгийн нөхөн төлбөрийн мэдээлэл, Бодь даатгал ХХК 2,133 нөхөн төлбөр авагчдын 819,1 сая төгрөгийн нөхөн төлбөрийн мэдээлэл, Монре даатгал ХХК 1,402 нөхөн төлбөр авагчдын 731,7 сая төгрөгийн нөхөн төлбөрийн мэдээлэл, Ард даатгал ХХК 926 нөхөн төлбөр авагчдын 506,9 төгрөгийн нөхөн төлбөрийн мэдээллийг хугацаанд нь ирүүлээгүй байна.

Даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн мэдээллийн чанарт хийсэн судалгааг үндэслэн дүгнэлт хийхэд даатгалын зуучлагч нарын шинээр хийсэн гэрээний мэдээллийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад анхааруулж байсан зөрчлүүд бүрэн арилаагүй, хариуцлагагүй хандлага хэвээрээ, мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргахгүй байна. Шинээр нэвтрүүлээд байгаа МИИС++ системийг ашиглаж, төрийн мэдээллийн ХУР систем, ТЦА, АТҮТөвүүдтэй хамтран ажиллаж мэдээлэл солилцсоноор даатгалын

гэрээний мэдээллүүд үнэн зөв бүрдэх, мэдээллийн сангийн мэдээллийн чанар сайжрах бололцоо бүрдэнэ.

Мэдээллийн сангаас Санхүүгийн зохицуулах хороонд 7 хоног болгон явуулдаг Жолоочийн даатгалын хүчинтэй гэрээ, даатгалын тохиолдлын тайланг огноогоор, даатгалын компаниар гэсэн үзүүлэлтээр ангилж 2019 онд нийт 37 удаа medeeler@frc.mn цахим шуудангаар илгээлээ. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 30, А/14 дүгээр хамтарсан тушаалаар “Жолоочийн даатгалын сангаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх түүнийг ашиглах журам”-ыг ТЦА-тай хамтран боловсруулж, батлуулснаар тээврийн цагдаагийн байгууллагад мэдээллийг цахимаар дамжуулж байна.

Цахим гарын үсэг болон хур систем ашиглан цахим байдлаар даатгалын гэрээ байгуулах систем боловсруулж ашиглалтад оруулсан бөгөөд энэ системийн шаардлагад нийцүүлэн 13 даатгалын компанид туршилтийн журмаар эрх олгон нэвтрүүлж байсан бол 2019 оны 8 дугаар сарын 01-нээс эхлэн эрх бүхий даатгагчид албан ёсоор ашиглаж эхлээд байна. Системийг нэвтрүүлэхдээ Миг, Монгол Бодь болон зуучлагчдын холбоо, банкны зуучлагчдын холбоо, Даатгалын холбоо, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамны холбогдох хүмүүсийг байлцуулан давхардсан тоогоор 10 гаруй удаагийн сургалт, танилцуулга хийлээ. Мөн бодит байдлаар Дархан уул аймагт тест хийж хөгжүүлэгчтэй 6 удаагийн хамтарсан туршилт хийж алдаа дутагдлыг засч сайжруулан хэвийн ажиллагааг хангасан байна.

МИИС системээс гарах мэдээллийн тайланг даатгалын компани тус бүрээр, газар нутгийн байршлаар, даатгалын гэрээний тоо, хураамжийн хэмжээгээр, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалт, нөхөн төлбөрийн идэвхижилт, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан тээврийн хэрэгслийн ангилал тус бүрээр төрөлжүүлэн гаргалаа. Үүнд:

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭ, ХУРААМЖИЙН ОРЛОГО

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компани 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, **674,441** жолоочийн даатгалын хүчинтэй гэрээ байгуулж, **36,571,605,045** төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын компани тус бүрийн байгуулсан жолоочийн даатгалын гэрээний тоог доорх хүснэгтээс харна уу.

Жолоочийн даатгалын хүчинтэй гэрээний тоо, хураамжийн дүн /өссөн дүнгээр/

Хүснэгт 3 /төгрөгөөр/

№	Нэрс	Нийт гэрээний тоо	Нийт хураамжийн дүн
1	Соёмбо даатгал	8,949	510,971,424
2	Миг даатгал	107,353	5,573,678,729
3	Мөнх даатгал	6,200	587,741,013
4	Монгол даатгал	130,666	6,991,290,258
5	Практикал даатгал	45,867	2,412,191,004
6	Амар даатгал	3,529	337,000,173
7	Улаанбаатар хотын даатгал	202	13,806,521
8	Номин даатгал	49,561	2,700,092,455
9	Тэнгэр даатгал	57,336	3,453,230,349
10	Бодь даатгал	100,073	4,798,755,458
11	Ган зам даатгал	576	49,746,280
12	Монре даатгал	53,567	3,106,245,041
13	Ард даатгал	51,300	2,668,573,332
14	Мандал даатгал	5,472	488,291,254


15	Хаан даатгал	53,790	2,879,991,754
2019 он		674,441*	36,571,605,045*

- *Даатгалын компаниудтай тулгалт хийсэн дүнгээр*

Жолоочийн даатгалын хүчинтэй гэрээний хураамжийн дүн /оноор/-г график 1-ээр харуулбал:

2019 оны албан журмын даатгалын хүчинтэй гэрээний хураамжийн орлогыг 2018 оны хүчинтэй гэрээний хураамжийн орлоготой харьцуулахад 15,6%-иар буюу 4,93 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 1.



2019 ОНД БАЙГУУЛСАН НИЙТ ГЭРЭЭНИЙ ТОО, ХУРААМЖИЙН ОРЛОГО БОЛОН ЦУЦЛАЛТ

2019 онд гишүүн 15 даатгалын компаниуд 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, нийт **700,617** даатгалын гэрээ байгуулж, **38,395,718,909** төгрөгийн хураамжийн орлого олох боломж бүрдсэн байна. Нийт **26176** гэрээ цуцлагдаж цуцлагдсан гэрээний нийт үнийн дүн **1,824,113,864** төгрөг байна. Даатгагчийн санаачилгаар цуцалсан 1,753,344,948 сая төгрөгийн 25107 гэрээ байгааг гүнзгийрүүлэн судлах боломжтой.

Нийт гэрээний тоо, хураамжийн орлого /Даатгалын компаниар/
/төгрөгөөр/

Хүснэгт 4

№	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн жолооч		Дамжин өнгөрөх		Нийт	
		Гэрээн ий тоо	Хураамжийн дүн	Гэрээн ий тоо	Хураамжийн дүн	Гэрээн ий тоо	Хураамжи йн дүн	Гэрээн ий тоо	Хураамжи йн дүн	Гэрээн ий тоо	Хураамжийн дүн
1	Соёмбо даатгал	6,928	270,029,656	2,531	303,176,151	325	8,319,712	1	327,037	9,785	581,852,556
2	Миг даатгал	77,930	2,958,205,036	30,826	2,767,408,650	1,543	40,572,556	110	13,757,711	110,409	5,779,943,953
3	Мөнх даатгал	1,591	60,170,586	2,052	225,966,699	283	7,622,174	2,413	301,619,502	6,339	595,378,961
4	Монгол даатгал	96,327	3,629,717,468	30,758	3,472,711,731	3,797	109,236,288	1,226	102,474,159	132,108	7,314,139,646
5	Практикал даатгал	34,995	1,260,073,005	11,815	1,189,274,003	1,326	34,518,321	192	17,182,564	48,328	2,501,047,893
6	Амар даатгал	1,639	71,706,780	1,592	154,156,428	65	1,797,013	441	144,978,176	3,737	372,638,397
7	Улаанбаатар хотын даатгал	157	6,296,746	91	9,525,330	1	26,400	0	0	249	15,848,476
8	Номин даатгал	38,301	1,516,800,290	11,386	1,280,674,302	1,784	55,346,266	26	2,863,179	51,497	2,855,684,037
9	Тэнгэр даатгал	42,499	1,729,518,604	14,869	1,783,745,795	1,389	36,261,676	58	6,515,828	58,815	3,556,041,903
10	Бодь даатгал	88,342	3,431,372,393	16,244	1,556,414,423	922	24,045,506	193	11,451,669	105,701	5,023,283,991
11	Ган зам даатгал	67	3,216,043	420	44,507,304	95	2,443,485	0	0	582	50,166,832

12	Монре даатгал	31,420	1,222,350,915	23,001	1,952,381,340	583	15,338,230	1	96,203	55,005	3,190,166,688
13	Ард даатгал	41,142	1,558,452,306	13,333	1,332,173,535	1,351	35,327,729	33	2,239,331	55,859	2,928,192,901
14	Мандал даатгал	2,616	185,681,562	3,355	359,561,418	99	2,756,325	2	413,127	6,072	548,412,432
15	Хаан даатгал	38,445	1,544,744,002	14,910	1,453,403,144	2,774	84,455,208	2	317,889	56,131	3,082,920,243
	Нийт	502,399	19,448,335,392	177,183	17,885,080,253	16,337	458,066,889	4,698	604,236,375	700,617	38,395,718,909

/Цуцлагдсан гэрээг оруулж тооцсон тул Хүснэгт 3-ын нийт гэрээний тоо, хураамжийн орлогоос зөрүүтэй болно./

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Албан журмын даатгагчдын холбооны даатгалын сангаас болон гишүүн 15 даатгалын компаниас 2019 онд нийт **33,286** жолоочийн даатгалын тохиолдолд **18,866,569,795** төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Даатгалын компани тус бүрийн хохирогчид олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг дараах хүснэгтээс харна уу.

Нөхөн төлбөр өссөн дүнгээр /даатгалын компани тус бүр/

Хүснэгт 5. /төгрөг/

№	Даатгалын компани нэр	Санхүүгийн тайлан	Нөхөн төлбөрийн дүн
1	Соёмбо даатгал	250	163,323,545
2	Миг даатгал	5,157	2,995,676,780
3	Мөнх даатгал	101	78,611,660
4	Монгол даатгал	6,204	3,628,342,099
5	Практикал даатгал	1,879	1,148,561,519
6	Амар даатгал	169	100,712,012
7	Улаанбаатар хотын даатгал	7	2,079,200
8	Номин даатгал	2,316	1,364,792,590
9	Тэнгэр даатгал	2,675	1,513,610,149
10	Бодь даатгал	5,352	2,646,890,092
11	Ган зам даатгал	22	18,600,700
12	Монре даатгал	3,156	1,728,732,350
13	Ард даатгал	2,140	1,286,278,247
14	Мандал даатгал	548	274,617,356
15	Хаан даатгал	3,309	1,911,741,496
16	АЖДХолбоо	1	4,000,000
	нийт	33,286	18,866,569,795

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХАРЬЦАА

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй 15 даатгалын компани 2019 онд **36,571,605,045** төгрөгийн хураамжийн орлого олж, **18,866,569,795** төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Хураамжийн орлогод нөхөн төлбөр **51,58%** хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос **1,82%-иар** буурсан байна.

2018-2019 оны жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцаа

Хүснэгт 6. /өссөн дүнгээр/

№	Нэрс	Нийт хураамжийн дүн /төг/		Нийт олгогдсон нөхөн төлбөрийн дүн		Хураамжийн орлогод н/т-ийн эзлэх хувь	
		2018	2019	2018	2019	2018	2019

1	Соёмбо даатгал	1,350,630,637	510,971,424	631,075,482	163,323,545	46.72%	31.96%
2	Миг даатгал	4,864,999,042	5,573,678,729	2,904,206,476.18	2,995,676,780	59.70%	53.75%
3	Мөнх даатгал	622,643,285	587,741,013	51,489,047	78,611,660	8.27%	13.38%
4	Монгол даатгал	6,199,369,417	6,991,290,258	3,074,826,462	3,628,342,099	49.60%	51.90%
5	Практикал даатгал	2,405,545,855	2,412,191,004	1,112,161,204	1,148,561,519	46.23%	47.61%
6	Гэр даатгал	158,350,164	337,000,173	249,648,560	100,712,012	157.66%	29.88%
7	Убхотын даатгал	8,509,094	13,806,521	1,742,000	2,079,200	20.47%	15.06%
8	Номин даатгал	2,034,684,131	2,700,092,455	1,104,270,802	1,364,792,590	54.27%	50.55%
9	Тэнгэр даатгал	2,168,741,400	3,453,230,349	1,039,487,219	1,513,610,149	47.93%	43.83%
10	Бодь даатгал	4,020,778,603	4,798,755,458	2,106,758,711	2,646,890,092	52.40%	55.16%
11	Ганзам даатгал	33,747,268	49,746,280	11,633,400	18,600,700	34.47%	37.39%
12	Монре даатгал	2,353,473,002	3,106,245,041	1,559,027,286	1,728,732,350	66.24%	55.65%
13	Ард даатгал	2,388,805,136	2,668,573,332	1,072,935,053	1,286,278,247	44.92%	48.20%
14	Мандаг даатгал	503,528,149	488,291,254	504,514,256	274,617,356	100.20%	56.24%
15	Хаан даатгал	2,455,778,436	2,879,991,754	1,434,522,656	1,911,741,496	58.41%	66.38%
16	АЖДХолбоо				4,000,000		
Нийт		31,569,681,364	36,571,605,045	16,858,662,936	18,866,569,795	53.40%	51.58%

*/*Үүнд Албан журмын даатгагчдын холбооноос олгосон нөхөн төлбөрийн дүн ороогүй болно./*

2019 оны байдлаар жолоочийн даатгалын хураамжийн орлого **15,8%-**иар 2018 оноос өсч 2018 онд нийт **16,858,662,936** төгрөгний нөхөн төлбөр олгосон бол 2019 онд **18,866,569,795** төгрөг нөхөн төлбөрт олгосон байна.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ КОМПАНИ

Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан **30** зуучлалын компани 2019 онд, **242,631** жолоочийн даатгалын гэрээ байгуулж, **11,942,110,861** төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. 2019 оны нийт гэрээний тоонд эзлэх хувь **35.9%**, нийт хураамжийн дүнд эзлэх хувь **32.6%** байна. Зуучлагчдын дунд **7** банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж нийт **71,425** гэрээ байгуулж, **3,122,714,492** төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлж нийт хураамжийн орлогын **8.8%** хувийг бүрдүүлжээ.

Жолоочийн даатгалын гэрээ өссөн дүнгээр /Зууч компаниар/

Хүснэгт 7. /төгрөгөөр/

№	Даатгалын зууч компани	Жолоочийн даатгалын гэрээний тоо	Жолоочийн даатгалын гэрээний хураамж	Нийт гэрээний тоонд эзлэх хувь	Нийт гэрээний хураамжид эзлэх хувь
1	Улаанбаатар хотын банк	65	2,952,589	0.0%	0.0%
2	Эм Эн Ай Би ХХК	6,420	389,653,369	1.0%	1.1%
3	Эн И Би Консалтинг ХХК	46	2,212,884	0.0%	0.0%
4	Хүннү Сиэл ХХК	1	128,304	0.0%	0.0%
5	Ренессанс групп ХХК	14	851,328	0.0%	0.0%
6	Бэст Солюшин ХХК	76	3,860,289	0.0%	0.0%
7	Ваяснью Солюшин ХХК	10,428	483,125,398	1.6%	1.4%
8	Дэвжих зууч ХХК	9,802	544,461,322	1.5%	1.5%
9	Ивээлт очир ХХК	972	47,105,989	0.1%	0.1%
10	Эм Жи Ай Би ХХК	8,251	460,656,027	1.3%	1.3%
11	МІВ	397	51,776,258	0.1%	0.1%
12	Нэйшнл Эженси ХХК	3,193	303,836,729	0.5%	0.9%
13	Тод Капитал ХХК	17,899	871,765,076	2.7%	2.5%
14	Цагаан гэрэлт ХХК	2,611	146,223,435	0.4%	0.4%
15	Си Эн Эн Икс ХХК	4,785	222,136,099	0.7%	0.6%
16	LBBrokerage ХХК	8,507	393,199,711	1.3%	1.1%

17	Худалдаа хөгжлийн банк	3,958	259,264,757	0.6%	0.7%
18	Мастер шийдэл ХХК	78	4,359,075	0.0%	0.0%
19	ХасБанк	767	46,650,571	0.1%	0.1%
20	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	26,927	1,372,767,356	4.1%	3.9%
21	Дэвжих дэлгэрэх ХХК	6,875	410,656,700	1.1%	1.2%
22	Ариг банк	5	285,120	0.0%	0.0%
23	Монгол бичээч ХХК	5,690	329,795,649	0.9%	0.9%
24	Төрийн банк	27,642	1,014,637,732	4.2%	2.9%
25	Ачит Ундарга ХХК	1,335	58,028,251	0.2%	0.2%
26	Эрсдэлийн шийдэл ХХК	14,310	689,157,512	2.2%	2.0%
27	Лоялти Солюшн ХХК	4,466	215,898,108	0.7%	0.6%
28	Хаан банк	12,061	426,156,367	1.9%	1.2%
29	Смарт брокерс ХХК	29,545	1,424,497,714	4.5%	4.0%
30	Сүрэг хараацай ХХК	35,505	1,766,011,142	5.4%	5.0%
	Нийт	242,631	11,942,110,861	37.2%	33.8%
	2019 онд нийт хийсэн гэрээний тоо, хураамж	674,441	36,571,605,045	100.0%	100.0%

ЖОЛООЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

Тээврийн хэрэгслийн ангиллаар нь 2019 онд даатгалын гэрээний тоог харвал **В** ангиллын тээврийн хэрэгсэл хамгийн их буюу **577,646** гэрээ байгуулж, **28,072,265,052** төгрөгийн хураамж төлжээ.

Жолоочийн даатгалын гэрээ /Тээврийн хэрэгслийн ангиллаар/

Хүснэгт 8

№	Зүйл	Даатгалын гэрээний тоо		Хураамжийн дүн	
		2018	2019	2018	2019
1	А	13,754	12,022	173,464,677	174,317,539
2	В	555,329	577,646	24,034,834,091	28,072,265,052
3	С	50,414	47,841	5,249,380,673	5,823,096,079
4	Д	14,947	14,287	1,335,376,841	1,510,401,733
5	М	5,263	5,484	154,761,943	193,948,023
6	Бусад	1547	17,161	231,963,194	797,576,619
	Нийт	641,254	674,441	31,179,781,419	365,571,605,045

/Бусад ангилалд мэргэшсэн жолоочийн гэрээ, хураамжийн дүн хамаарна,

МЭДЭЭЛЛИЙН САН, ШУУРХАЙ ДУУДЛАГЫН ЛАВЛАХ ТӨВИЙН УТСААР ОЛГОСОН ЛАВЛАГАА

Хүснэгт 9.

№	Дуудлагын утга	2018 онд ирсэн дуудлагын тоо	2019 онд ирсэн дуудлагын тоо
1	Нөхөн төлбөр, даатгалын сангийн лавлагаа	708	563
3	Хууль тогтоомжийн лавлагаа	14	292
5	Мэдээллийн сангийн лавлагаа	660	1544
6	Даатгалын гэрээний лавлагаа	1031	1056

7	Санал гомдол	12	57
8	Итгэлцүүрийн журмын талаарх лавлагаа	32	23
9	АЖДХ ажилтны лавлагаа	42	22
10	Даатгалын компаний утасны дугаар, хаяг байршил	39	328
11	Бусад	61	384
НИЙТ		2599	4269

Мэдээллийн сан, шуурхай албаны дуудлагын утсанд 2019 онд нийт 4269 дуудлага бүртгэгдэж 2018 онтой харьцуулахад 60,8%-иар өссөн байна. Цаашид мэдээллийн санд цугларч байгаа даатгалын мэдээллийн чанарт онцгой анхаарч ажиллах талаар даатгагч, даатгалын зуучлагч зэрэг байгууллагатай ярилцаж хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах шаардлага байна.

2.3 ДААТГАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХОХИРОГЧ, ИРГЭНЭЭС ДААТГАЛЫН ТОХИОЛДЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ ШУУРХАЙ ҮНЭН ЗӨВ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖИЙГ ДААТГАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХОХИРОГЧИД БҮРДҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ШУУРХАЙ АЛБАНЫ ТАЛААР:

Шуурхай алба нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.2; Жолоочийн даатгалын тухай хуулийн 25.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж хохирогчдод туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ салбарын шуурхай албаны үйл ажиллагаанд хяналт тавьж зааварчилгаа өгөх, орон нутгийн замын цагдаагийн тасаг болон авто тээврийн газруудтай хамтран шалгалт хийж даатгалд хамрагдаагүй, даатгалын гэрээний хугацаа нь дууссан жолооч нарыг илрүүлэх, зөрчлийг арилгуулах, улмаар даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж байна.

Албан журмын даатгалын шуурхай албаны үйл ажиллагаа шинэ техник технологид суурилан чирэгдэлгүй шуурхай ажиллах, зам тээврийн ослын тодорхой тохиолдолд замын цагдаагийн оролцоогүйгээр нөхөн төлбөр олгох нөхцлийг бүрдүүлэх үүргийг хэрэгжүүлж байна. Шуурхай албаны ажилтнууд даатгалын тохиолдлын мэдээлэл хүлээн авч замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох эрх зүйн мэдлэгтэй, нөхөн төлбөр олгох үндсэн баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэхэд хохирогчид зөвлөгөө өгөх хэмжээнд, мэргэшсэн байх шаардлагад нийцүүлж “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албыг ажиллуулах түр журам”-ыг боловсруулан Холбооны Удирдах Зөвлөлөөр батлуулан ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 02/09 тоот “Загвар батлах тухай” тушаалаар даатгалын шуурхай албаны автомашины таних тэмдэг, дуудлагын ажилтны өмсгөлийн загварыг шинээр батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Албан журмын даатгагчдын холбооны Удирдах Зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 06 тоот тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай алба даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч, үйлчлэхэд баримтлах жишиг үнийн тариф”-ыг шинээр батлуулан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шуурхай албаны үйлчилгээ үзүүлэх тухай” гэрээнд тусгах замаар улсын хэмжээнд шуурхай албаны үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүллээ.

Жолоочийн даатгалын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журмуудын хэрэгжилтийг хангуулах, зам тээврийн ослын улмаас иргэд, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг шуурхай үнэн зөв тодорхойлох боломж бүрдүүлэхээр орон нутагт Холбооны шуурхай албатай “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шуурхай албаны

үйлчилгээ үзүүлэх тухай” гэрээг Амар, Улаанбаатар хотын даатгал компаниудтай байгуулан ажиллалаа.

Албан журмын даатгагчдын холбоонд 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Харилцаа холбооны зохицуулах хорооноос 1800-1177 тусгай дугаарыг эзэмших бүртгэлийн гэрчилгээ авлаа. Тусгай дугаараар дуудлага хүлээн авахын тулд Монголын Цахилгаан Холбоо, Мобиком, Юнител, Скайтел, ЖиМобайл компаниудтай харилцаа холбооны шугам ашиглах гэрээ байгуулж тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолооч нарт гэрээний хугацааг мэдээлэх, цахим даатгалын баталгаажуулат хийх зэрэг үйлчилгээг нэвтрүүллээ.

Даатгалын тохиолдол гарсан үед мобайл “АЖД” аппликейшн ашиглан тээврийн цагдаагийн албанд шаардагдах асуултад хариулж, тухайн осолд өртсөн жолооч нар замын цагдаагийн оролцоогүй даатгалын компанийн шуурхай албанд хандах, учирсан хохирлын зураг, бичлэгээ тухайн даатгалын тохиолдлын газраас явуулж үнэлүүлэх зэрэг давуу тал бүхий аппликейшн, МИИС++ системийг нэвтрүүлсэнтэй холбоотой ТЦА-аас даатгалын тодорхойлолтыг цахимаар өгөх боломж бүрдсэн бөгөөд энэ нь даатгалын байгууллага, цагдаагийн байгууллага дээр биечлэн очихгүй, үйлчилгээг онлайнаар авах боломжийг жолооч нарт бүрдүүллээ.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт Тээврийн цагдаагийн алба, Авто тээврийн үндэсний төв, Бүртгэл хяналтын төв зэрэг байгууллагуудтай хамтран оролцож, иргэдэд тулгамдсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэн хууль эрх зүйн туслалцаа үзүүлж ажиллалаа. Өдөрлөгийн үеэр Монгол бичээч зууч компани 36 жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хийлээ. Тээврийн цагдаагийн алба, Миг даатгал компанитай хамтарч хүүхдийн гэнэтийн ослыг бууруулах, болзошгүй эрсдэлээс хүүхдүүдээ хамгаалъя гэсэн уриан дор “Хамгаалагдсан ирээдүй” төслийн уралдааныг хэрэгжүүлэхэд оролцлоо.

Жолоочийн даатгалын нэгдсэн дуудлагын төвийг 2019 оны 8 сарын 1-ний өдрөөс эхлэн туршилтын 3 сарын хугацаатай, 24/48 цагийн ээлжээр ажиллах зохион байгуулалтанд оруулж 3 ээлжийн оператортойгоор ажиллав. Тайлант хугацаанд, МИИС системд даатгалын компаниудын нийт 981 дуудлага хүлээн авч даатгалын тохиолдлын дуудлага бүртгэгдэж үүнээс 112 дуудлага нь 1800-1177 утсаар дамжин даатгалын компани руу шилжүүлсэн байна. Энэ ажлын үр дүнг Удирдах зөвлөлд танилцуулж цаашид үргэлжлүүлэн ажиллуулах чиглэл аваад ажиллаж байна.

2.4 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХ, АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТАЛААР ОЛОН НИЙТЭД МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ОЛГОХОД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ НЬ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН АЧ ХОЛБОГДЛЫГ ТАНИУЛАХ ХӨШҮҮРЭГ БОЛЖ БАЙНА.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, Жолоочийн даатгалын хууль, тогтоомжийг сурталчлах, даатгалын ач холбогдлыг таниулах, зам, тээврийн ослын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чадварыг олон нийтэд төлөвшүүлэх, зөв дадалд хэвшүүлэх, хариуцлагын даатгалын үйлчилгээг хэрхэн сайжруулах, даатгалын харилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах зэрэг ажлыг иргэд олон нийтэд сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Үүнд:

TV9 телевизийн “Гарц” нэвтрүүлгээр Албан журмын даатгагчдын холбооны 2018 оны үйл ажиллагаа, АЖДХ болон ТЦА-ны хамтын ажиллагаа, Монгол улсын Замын

хөдөлгөөний шинэчилсэн дүрэм, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, техникийн хяналтын үзлэг, жолоочийн хариуцлагын даатгал орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа талаар, МИИС++ insuretech цахим даатгалын системийн туршилт Дархан хот, орон нутаг дахь даатгалын шуурхай албаны дуудлага, нөхөн төлбөрийн үйлчилгээ зэрэг сэдвээр нэвтрүүлэг бэлтгэж хамтран ажиллах гэрээний дагуу сард 2 удаа тогтмол цагт хуваарийн дагуу давталттайгаар нэвтрүүлсэн.

SBN, TV4, UBS, MNC, TV6, LiveTV, “Эх орон”ТВ, МҮОНТВ “Цагийн хүрд” нэвтрүүлэгт Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар мэдээлэл, тодруулга өгч Bloomberg TV-д Гүйцэтгэх захирал Д.Цэвээнжав, Даатгалын сангийн ахлах ажилтан Д.Тунгалаг нар оролцож Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар ярилцлага өглөө.

МҮОНРадиоогийн хууль зүйн мэдээллийн “Соёмбо” нэвтрүүлэгт хуваарийн дагуу сар бүр оролцож Холбооны 2018 оны үйл ажиллагааны хэрэгжилт, цаашдын зорилт, 2018 онд байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн хэрэгжилт, 2019 онд байгууллагууд хэрхэн хамтран ажиллах талаар, Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийн 3.5г, 3.6 дахь заалтын хэрэгжилт, анхаарах асуудал, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ, түүнийг хэрхэн сайжруулах талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цаашдын зорилт, орон нутаг дахь техникийн хяналтын үзлэгийн явц, жолоочийн даатгалд хамрагдалт, даатгалын шуурхай албаны болон нөхөн төлбөрийн үйлчилгээ, МИИС++ insuretech буюу МИИС системийн хөгжүүлэлт цахим даатгалын систем, Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, даатгалын дуудлагын нэгдсэн төвийн тухай зэрэг сэдвээр нэвтрүүлэг бэлтгэж орон даяар нэвтрүүлсэн.

МҮОНРадиоогийн Авторадио шууд нэвтрүүлэг, 106, 105,5 зэрэг fm радиогоор МҮОНРадиоогийн Тэнхлэг хөтөлбөрийн Соёмбо нэвтрүүлгийн давтан дамжуулалтад Чингэлтэй дүүргийн ЗЦТ-ийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зохицуулагч Б.Өнөболдтой хамт 96,3, Kiss 100,1 зэрэг шууд нэвтрүүлгүүдэд хамтран ажиллах гэрээ, хуваарийн дагуу тогтмол оролцож, жолооч, даатгуулагчдын саналыг сонсч, сонирхсон асуултуудад хариу өгч ажиллалаа.

“За рулём Монголия” сэтгүүл, Засгийн газрын мэдээ сонинд реклам, баннер байршуулан TV9 телевизийн Гарц нэвтрүүлгийн дундуур болон МҮОНРадиоогийн Хурд агентлагийн Мэдээ хөтөлбөрийн дундуур шторк цацаж Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг сурталчлах, жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдол, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх болон цаг үеийн холбогдолтой сэдвээр сурталчилгааны ажлыг явуулж Facebook, twitter, инстаграм, линкедлин, youtube зэрэг сошиал сувгаар зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, даатгалын ач холбогдлыг таниулах агуулга бүхий постыг тогтмол байршуулж сурталчиллаа.

VIP76.mn, AMI.mn сайтад Албан журмаар даатгуулсан жолоочид “Урамшуулал” байж болохгүй юу?, “Цахим даатгалыг хөгжүүлье” нийтлэлүүдийг, “Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах цаг болсон” ярилцлагыг, ubinfo.mn, Zgm.mn, gogo.mn, ami.mn сайтуудад Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар инфографик байршуулж сурталчиллаа.

Замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх дадал хэвшил, соёлыг олон нийтэд төлөвшүүлэх чиглэлээр “За рулём Монголия” сэтгүүлтэй хамтран ажиллаж сар бүр 10,000 ширхгийг хэвлүүлж, үнэгүй тараан Согтууруулах ундааны

зүйл хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодохгүй байхыг анхааруулах, гүйцэж түрүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэх, 2018 оны жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний тоо, хураамжийн дүн, даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн дүн зэргийг 2017 оны статистик үзүүлэлттэй харьцуулсан инфографик, “Жолооч дараах баримт бичгийг шалгуулах үүрэгтэй”, “10 хүртэлх насны хуухэд замын хөдөлгөөнд хэрхэн оролцох, унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд хэрхэн оролцох”, Жолоочийн даатгалын дуудлагын нэгдсэн төв байгуулагдсан тухай, “Хүүхдийг хэрхэн зөв тээвэрлэх”, “Хороолол доторх замын хөдөлгөөн”, “Саадыг тойрон гарах”, хүүхдийн суудлын олон улсын стандарт болон амин бүсийн талаарх “амин бус” реклам, самбарыг байршуулан олон нийтэд сэрэмжлүүлэг, сануулга болгон сурталчиллаа. Мөн “За рулём Монголия” сэтгүүлийн сар бүрийн дугаарын 38-р нүүрэнд иргэд, даатгуулагч нарын асуусан, сонирхсон асуултад тогтмол хариулт өгч байна.

Монголын Субару сонирхогчдын групп, Paparazzi+Trafic Mongolia, Монголын автомашин хэрэглэгчдийн холбоо, Приус эзэмшигчдийн нэгдсэн групп, Замын цагдаагийн алба, Цахим замын цагдаа, Орон нутгийн замын цагдаа, Монголын радио, Кузов засвар хоббичид зэрэг 2,8-184,0 мянган дагагчидтай пейж хуудсуудад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх агуулгатай постуудыг байршуулж сурталчилж байна.

Замын хөдөлгөөний соёлыг хэвшүүлэх, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд хүргэх “Нэг хором” ухуулга, нөлөөллийн арга хэмжээг Тээврийн цагдаагийн алба, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран улсын хэмжээнд зохион байгуулав. Мөн, ТЦА, Нийслэлийн боловсролын газар, УЗН зэрэг байгууллагуудтай хамтран уламжлал болон 38 дахь жилдээ зохион байгуулагдсан Ногоон гэрэл цагаан шугам-2019 тэмцээнийг сургуулийн өмнөх болон ЕБСургуулийн сурагчдын дунд зохин байгуулж сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох чиглэлээр, Шилдэг зохицуулагч-2019 тэмцээнийг замын цагдаагийн алба хаагчдын дунд зохион байгуулж хууль эрх зүй, гадаад хэлний мэдлэг, биет зохицуулалт, зам тээврийн ослын газарт ажиллаж дүгнэлт гаргах, уран жолоодлого гэх мэт ур чадвар, мэдлэгийн 7 төрлөөр 33 багийн алба хаагчдыг оролцуулан шилдгүүдийг тус тус шалгаруулан байр эзлүүлж урамшууллаа. Зам тээврийн хөгжлийн яам, тээврийн цагдаагийн алба, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагын чадавхийг сайжруулах нь” техник туслалцааны төслүүдтэй хамтран Амин бүс сэдэвт олон нийтийг хамруулсан компанит ажлыг СХДүүргийн ЕБСургуулиуд, хороодод зохин байгууллаа.

Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөр “/2019-2023/батлагдсан. Энэ дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулж батлуулах “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ын төсөл, танилцуулгыг Зам, тээврийн хөгжлийн сайдаас 2019.5.31-ний өдөр 01-2890 тоот албан бичгээр ирүүлснийг судалж, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ын болон “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөлд 2019 оны 6 дугаар

сарын 11-ний өдрийн 02/171 тоот албан бичгээр холбогдох санал хүргүүлж тусгуулан ажиллаж байна.

Орон нутгийн замд хурд хэтрүүлснээс үүдэн гарсан зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд олноор хохирч байгаа нь орон нутгийн замд чиглэсэн цогц үйл ажиллагаа явуулах шаардлага бий болгож байна. Орхон, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв зэрэг аймгуудын улсын чанартай авто замын хөдөлгөөн ихтэй хэсгүүд болон эргэлтийн цэгүүдэд зам тээврийн ослоос урьдчилан анхааруулах самбар 98 ширхгийг байршууллаа. Зам тээврийн хөгжлийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яамнаас эрхлэн гаргасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном”-ыг 1000 ширхэг хэвлүүлж хэрэгцээтэй газруудад түгээлээ.

Хан-уул дүүргийн ГХУСАЗСЗөвлөл болон прокурорын газар, ТЦАлбатай хамтран хууль тогтоомжийг сурталчлах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жил бүр зохион байгуулдаг “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээнд оролцож, Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагааны талаар лавлагаа мэдээлэл өгөх, иргэдэд даатгалын ач холбогдлын талаар мэдлэг олгох үзүүлэн самбар, гарын авлага, материал зэргийг бэлтгэн танилцуулах, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдахын ач тусыг ойлгуулах, тэдний санал хүсэлтийг сонсож үйл ажиллагандаа тусгаж ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанаас хамтран хэрэгжүүлж буй "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл", "Яараад яахав дээ", "Дураараа биш дүрмээрээ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд улсын чанартай болон орон нутгийн авто замд хяналт шалгалт хийх, иргэдэд мэдээлэл өгөх, ихэнх нутгийг хамарсан цаг агаарын нөхцөл байдал, цас, борооны улмаас замд халтиргаа гулгаа үүсэх, шаварт суух зэрэг автозамын гадаргуу, зорчих хэсэгт хүндрэл үүсч болзошгүй талаар санамж сэрэмжлүүлэг, анхааруулга өгөх зэргээр орон нутгийн цагдаагийн хэлтэстэй хамтран ажиллаж хэвшээд байна.

Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Дархан-Уул аймагт зохион байгуулсан Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн хэрэгжилт сэдэвт сургалтад ТЦА-ны Захиргаа удирдлагын газрын ахлах, цагдаагийн хошууч Ж.Галсанжамц оролцож, Монгол улсын замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийн талаар сургалт хийлээ.

Монголын даатгалын холбоотой хамтран АЖДХ-ны Шуурхай албыг түр ажиллуулах журам болон МИИС системийн хөгжүүлэлтийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. СЗХ, МДХ, Монголын даатгалын институттэй хамтран зохион байгуулсан Ердийн даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалтад оролцож Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль эрх зүй, жолоочийн даатгалын гэрээ байгуулах арга зүй, гэрээ байгуулахад анхаарах зүйлс, МИИС++ болон МИИС програм ашиглах тухай сэдвээр сургалт явууллаа.

Монголын даатгалын зуучлагчдын холбооноос зохион байгуулсан “Mongolian insurance brokers conference 2019”-д оролцож даатгалын брокер компаниудын алдаа оноо болон дэмжлэг, программын сайжруулалтын талаар илтгэл танилцуулсан.

Холбооны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот бүлэгт чиглэсэн сургалт сурталчигааг зохион байгуулах ажлын хүрээнд Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвийн харилцагч нарт 3 удаа/65/, Таван богд фүүдс ХХК-ийн түгээлтийн жолооч нарт 3 удаа/72/, АПУ ХХК-ийн инженер техникийн ажилтнууд болон жолооч нарт 2 удаа/55/, Жон бээс авто сургуулийн төгсөгч нарт 2 удаа/43/, ХСИС дээр 1 удаа/19/ ЧД-ийн СӨБ-ын эрхлэгч, багш нарт/28/

Жолоочийн хариуцлагын даатгал, түүний ач холбогдол сэдвээр; ЗЦА-ны төв орон нутгийн ахлах зохицуулагч нарт 3 удаа/51/, Нарийн сухайт чиглэлийн авто замын засвар арчлалтын компанийн инженер техникийн ажилтнуудад/12/, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоотой хамтран “Эрдэм транс”, “Сутайн буянт”, “НЧБ”, “Автотерминал” зэрэг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын тээвэр зохицуулагч нарт/27/, тус Холбооноос зохион байгуулсан техникийн оношилгооны төвүүдийн инженерүүдэд мэргэшсэн инженерийн эрх олгох сургалт, Зам тээврийн хөгжлийн яамнаас ШУТИС-ийн Механик тээврийн сургуультай хамтран зохион байгуулсан АТҮТ-ийн бүртгэлийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад Жолоочийн даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал сэдвээр тус тус сургалт зохион байгууллаа.

Холбооны ажилтнуудад МИИС++ insuretech цахим даатгалын систем болон АЖДХ-ны Шуурхай албыг түр ажиллуулах журмын талаар дотоод сургалт зохион байгуулсан. Мөн дээрх сэдвээр орон нутаг дахь салбарын менежерүүдэд онлайн сургалтыг тогтмол зохион байгуулж харилцан уялдаа холбоотой ажиллалаа.

Харилцаа холбоо мэдээллийн технологийн газраас уламжлал болгон зохион байгуулдаг “ICT-Expo 2019” үзэсгэлэн “Технологи таны амьдралд” уриан дор зохион байгуулагдсан бөгөөд энэ үзэсгэлэнд Айтүүлс ХХК, MIG даатгал ХХКомпаниудтай хамтран оролцож жолоочийн даатгалын үйл ажиллагаанд хөгжүүлсэн програм хангамж амьдралд хэрхэн хэрэглэгдэж байгааг олон нийтэд танилцуулж сурталчилсан.

Хүүхдэд учирч буй ослын шалтгаан, нөхцөлийг бууруулах оновчтой шийдлүүдийг олж хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор улс орон даяар хүүхдийн гэнэтийн ослын шалтгаан нөхцөлийг бууруулах шийдлийг олох “Хамгаалагдсан ирээдүй” төслийн уралдааныг Гэмтэл согог судлалын үндэсний төв, Тээврийн цагдаагийн алба, СЭЗИС, Даатгал эрсдэлийн академи, Актуарчийн институт, МИГ Монголын иншуртек групп-тэй хамтран зохион байгуулж шилдэг 5 төслийг шалгаруулахад оролцлоо.

СЗХ, ОБЕГ, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, MEFIN байгууллагын хамтран зохион байгуулсан Climate risk insurance conference Mongolia, “Орон нутгийн зам- хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хэвлэлийн бага хурал, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Авто их бие засварын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог бий болгох сэдэвт уулзалт семинар зэрэг үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай оролцлоо.

ГУРАВ. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХОЛБООНЫ ДОТООД АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ.

3.1. Санхүүгийн үр дүнгийн талаар

Холбооны үйл ажиллагааны тайлан, нийслэл, 21 аймгаас Жолоочийн даатгалын санд төвлөрүүлсэн орлогын мэдээ тайланг аймаг нийслэлээр гаргаж сар бүр ажилчдын цалин хөлсний тооцоог хийж, нийгмийн даатгалын тайлан, ХХОА тайланг нэгтгэн СЗХороо болон холбогдох байгууллагуудад тайлагналаа. /Санхүүгийн тайланг www.ami.mn цахим хуудсанд байршуулсан./

2018 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, Сүлд аудитаар хөндлөнгийн аудитыг хийлгэж дүгнэлтийг Удирдах зөвлөлд танилцуулан Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн болно. Дүгнэлтийг өдөр тутмын “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонингуудад нийтлүүлж олон нийтэд мэдээллээ.

ЖДСангийн нийт хөрөнгийн 88.8% нь мөнгөн хөрөнгөөр, 10.6% нь үндсэн болон биет бус хөрөнгөөр, 0.6 % нь нөхөн төлбөрийн авлага болон БМҮБЗүйлээр байршиж байна.

3.2 Орон нутгийн салбарын үйл ажиллагаа, үр дүн

МИИС++ шинэ системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан орон нутагт дахь даатгалын компаниудаас ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх, MONPASS цахим гарын үсэг олгохтой холбоотой программыг нэвтрүүлэх ажлыг идэвхи санаачилгатай гүйцэтгэж Холбооны мэдээллийн сан, шуурхай албаны ажилтнуудтай байнгын уялдаа холбоотой ажиллан даатгалын компаниудын салбарын ажилтнуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. 2012-2019 онуудын хооронд 21 аймагт бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо, техникийн хяналтын үзлэг оношлогоонд хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо, татвар төлсөн тээврийн хэрэгслийн тоонуудын харьцуулсан судалгааг гаргалаа. Холбооны шуурхай албаны ажиллах журмын дагуу салбарын үйл ажиллагааг явуулж, дуудлагыг 24 цагаар авч бүртгэн, тухайн өдрийн мэдээг өдөр бүр shuurhaialba@ami.mn хаягаар хүлээн авч нэгтгэж байна. Албан журмын даатгагчдын холбоо, ТЦА-ны хооронд байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн дагуу Завхан, Дундговь, Ховд, Төв, Хөвсгөл, Сүхбаатар, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Архангай, Увс, Баян-Өлгий, Дорнод, Дорноговь зэрэг аймгуудад ЗЦТ-тай хамтарсан хяналт шалгалтын арга хэмжээ зохион байгуулж, 3119 тээврийн хэрэгсэл шалгаж, жолоочийн хариуцлагын даатгалгүй, гэрээний хугацаа нь дууссан зэрэг зөрчилтэй 787 жолооч илрүүлэн даатгалд хамруулж ажиллалаа.

Хяналт шалгалтын үйл ажиллагааг тээврийн цагдаагийн албатай хамтран зохион байгуулсан нь даатгалгүй жолоочийг илрүүлэх, жолооч нарын хариуцлагыг нэмэгдүүлж жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалт өмнөх оны мөн үеэс өсөхийн зэрэгцээ Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч байна.

Орон нутаг дахь салбарын менежерүүд 2019 онд 2 удаа Улаанбаатар хотод сургалт, семинарт хамрагдан мэдлэг мэргэшлээ дээшлүүлж зам тээврийн ослын үед эмнэлгийн яаралтай ахан шатны тусламж үзүүлэх, даатгалын хохирол үнэлгээний чиглэлээр тусгайлсан сургалтад хамрагдаж сертификат олгууллаа.

3.3. Эрх зүйн актуудыг боловсронгуй болгоход чиглэсэн ажил, дотоод хяналт, салбар, нэгжийн ажил дүгнэсэн тухай

Жолоочийн даатгалын тухай хууль, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, төслийн танилцуулгыг шинэчлэн бэлтгэж Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан холбогдох ажлын хэсэгт хүргүүллээ.

ОХУ-ын даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт, зам тээврийн осол гарсан үед жолоочийн анхаарах арга хэмжээний схем, ОХУ, Япон, Австрали улсуудын албан журмын даатгалын талаархи хууль, холбогдох материалыг орчуулан харьцуулсан судалгаа хийж байгаа бөгөөд Япон, БНХАУ болон ОХУ-ын зам тээврийн ослын үед хэрэглэх тохиолдол/case/-ыг орчуулан нэвтрүүлэх боломжийг судалж байна.

Холбооны дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг боловсронгуй болгох, орхигдуулж хийдүүлсэн зүйл заалт байгаа эсэх дээр судалгаа хийж ажилтнуудын саналыг тусган өөрчлөлт оруулахаар бэлтгэж байна.

Даатгуулагчид, Холбооны ажилтнуудад зориулсан эрх зүйн актын эмхэтгэл гарын авлагын эхийг боловсруулан хэвлэлтэд өгөхөд бэлэн болгоод байна. Энэхүү гарын авлага нь даатгалын салбарын эрх зүйтэй холбоотой хууль, дүрэм, журам, Холбооны үйл ажиллагаанд дагаж мөрдөх Удирдах зөвлөлийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал зэргийг нэг дор багтааснаараа чухал ач холбогдолтой юм.

Орон нутаг дахь менежерүүдтэй онлайнаар холбогдон орон нутагт явуулах сургалт, сурталчилгааны ажлыг шинээр нэвтрүүлж байгаа МИИС++, шуурхай албаны дуудлагын төвийн ажил үйлчилгээтэй уялдуулан сургалт, заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

2019 онд Увс, Баянхонгор, Хэнтий, Дорнод, Дархан уул аймгууд дахь салбарын үйл ажиллагааг газар дээр нь очиж шалган, орон нутаг дахь даатгалын компаниудын салбарын ажилтнууд болон нутгийн удирдлага, төрийн болон бусад байгууллагын ажилтнуудтай уулзаж санал бодлыг нь сонсч үйл ажиллагаандаа тусгав.

Тайлант хугацаанд холбооны Гүйцэтгэх захирлын 2016 оны 02/139 дүгээр тушаалаар батлагдсан “Албан журмын даатгагчдын холбооны улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж Гүйцэтгэх захирлын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 02/11 тоот тушаалаар батлуулан ажилтнуудын ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэж урамшууллаа. Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн 2 ажилтанд Гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын шийтгэл хүлээлгэж алдаа дутагдлаа засч ажиллахыг үүрэг болгосон байна.

Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 02/22 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэсэгчлэн шалгаж ажлын хэсгийн санал дүгнэлт, танилцуулга гаргаж алдаа дутагдлыг засч ажиллалаа.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт:

2018 онд, орон нутагт бүсчилсэн 8 салбартайгаар ажиллаж байсан бол, жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагааг хуулинд заасны дагуу хэрэгжүүлэх зорилгоор орон нутаг дахь Засаг даргын тамгын газар болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүсэлтийг үндэслэн 2019 оны 1 дүгээр сараас 20 аймагт Холбооны салбарыг ажиллуулж даатгалын хохирол үнэлэх чадвартай, яаралтай тусламж үзүүлэх мэргэшсэн хүний нөөцтэй мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Удирдах зөвлөлөөс үүрэг болгосны дагуу эхний хагас жилд багтаан МИИС системд өргөтгөл хийж, даатгалын хураамжийг бэлэн бусаар тооцож, гэрээ байгуулагдсаныг баталгаажуулах боломж бий болгов. МИИС системд сүүлийн нэг жилд хэдэн удаа нөхөн

төлбөр авсан тоо, нийт авсан хэмжээг харуулах цонхыг шинээр нээж, даатгалын дуудлага, газар дээрх тэмдэглэлийн бүртгэл, хохирол үнэлгээний дугаарыг МИИС системд нэгдсэн байдлаар бүртгэх зэрэг ажлуудыг цогцоор шийдвэрлэн мэдээллийн Хур нэгдсэн систем, Гэрэг системс ХХК, Найшнл блокчейн платформ ХХК-тай тус тус хамтран ажилласнаар МИИС++ системийг ашиглалтад орууллаа. Зөвхөн онлайн даатгал хийх бус нэгдсэн тайлан, мэдээг хууль, холбогдох эрхзүйн актад заасны дагуу ТЦА, СЗХороонд хүргүүлэх, холбогдох байгууллагуудтай мэдээ солилцох боломж сайжирч байна.

Ялангуяа, даатгуулагчдад чирэгдэлгүй, байгаа газраасаа онлайн даатгалыг өөрийн сонголтоороо хийх, даатгагчдын ажлын тайлан, мэдээ үнэн зөв нэгтгэгдэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай мэдээ, мэдээлэл солилцох боломжууд нээгдсэн гэж үзэж байна. Холбооноос гишүүд болон даатгуулагчдын эрх ашигт нийцсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажил тийм амар хялбар хэрэгжээгүй гэдгийг тэмдэглэж, санаачилгыг дэмжиж хамтран ажиллаж байгаа даатгалын компаниудын дэмжлэг, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд мэдээллийн сангийн үйл ажиллагаа улам хөгжиж байна. Жолоочийн даатгалын хураамжийн орлогын 50 орчим хувийг зарцуулдаг зам тээврийн ослын хохирогчид нөхөн төлбөр олгох үндэслэл болсон шуурхай албаны үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглан хяналт тавих боломжийг бүрдүүлээ.

Цаашид анхаарах асуудал:

2018 оны жилийн эцэст дэвшүүлсэн цаашид анхаарах асуудлуудыг 2019 оны үйл ажиллагаандаа тусган шийдвэрлэх, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шуурхай албаны журмыг шинэчлэн батлах, бусад холбогдох журмын зөрчилтэй заалтыг засах, хоорондоо зөрчилтэй эрх зүйн актуудыг уялдуулах зэрэг асуудлууд шийдвэрлэгдэхгүй, удаашралтай байгаагаас хэрэгжүүлэгч байгууллагууд холбогдох эрх зүйн актуудын зүйл заалтыг өөрсдийн үзэл бодлоор дур мэдэн тайлбарлаж даатгуулагчийг хохироож чирэгдүүлэхгүй байхад анхаарах, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ байгуулахдаа “нэр дурдсан жолооч” гэх хуулинд байхгүй нэр томъёо гарган гэрээнд нэр бичигдсэн жолооч нарыг даатгалтай этгээд гэж тооцож,гэрээнд нэр нь бичигдээгүй бол тээврийн хэрэгсэл нь даатгалтай байсан ч Холбооноос нөхөн төлбөр нэхэмжлэх зэрэг зохисгүй үйлдэл гарсаар байгааг зохицуулж Жолоочийн даатгалын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг нэг мөр ойлголттой болгох, “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцож итгэлцүүр хэрэглэх журам”-ын талаар тус Холбооноос хүргүүлсэн санал, хүсэлтийг хэлэлцэж зөрчлийг арилгах, зарим эрхзүйн актуудыг нэгмөр ойлголттой болгоход Санхүүгийн зохицуулах хороо анхаарал тавихыг хүсч байна.

Холбооноос, Жолоочийн даатгалын тохиолдлын дуудлага төвлөрүүлэн хүлээн авах төвд Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дуудлага, мэдээллийг холбох асуудлыг судалж “102” дуудлагын утсанд ирж байгаа дуудлага нэг бүрийг бүртгэх, бүртгэсэн дуудлагыг шууд даатгалын компани руу шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавих, СЗХорооны тогтоолоор баталдаг “Гэрээний стандарт загвар”-ын хавсралтад дуудлагын төвийн “1800-1177”, “АЖД” аппликейшнийг хэрэглэх тухай нэмэлт оруулах, ангилал тогтоогдсон засварын төвүүдээс хохирол үнэлгээний мэдээлэл авах боломж бий болгох, бүртгэл, оношлогооны төвтэй хамтран даатгуулагчдын эрх ашигт

нийцсэн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагааг нэвтрүүлэхэд анхаарлаа хандуулж, ирэх онд хэрэгжүүлж эхлэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллаж мэдээлэл солилцох арга замыг нээх ажлыг улам идэвхижүүлэх, Жолоочийн даатгалын тухай хуулийг шинэчилсэн найруулгын хэмжээнд боловсруулах, жолоочийн хариуцлагын даатгалыг хэрэгжүүлэх тогтолцоог өөрийгөө зохицуулах зарчмаар хэрэгжүүлэх боломжийг нээж өгөх зэрэг асуудлыг судалж үзэх нь зүйтэй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

Албан журмын даатгагчдын
холбооны гүйцэтгэх захирал

Д.ЦЭВЭЭНЖАВ

Ажлын албаны дотоод хяналт хариуцсан

ахлах ажилтан

Б.Эрдэнэцэцэг

Даатгалын сангийн дарга, ерөнхий санхүүч

С.Хишигзаяа

Мэдээллийн сангийн дарга

Т.Шинэцэрэг

Шуурхай албаны дарга

Б.Батзориг